

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ДОТООД
ХЯНАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 4 ДУГААР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022 -12-15.

№	Хянал шалгалт хийх чиглэл	Үйл ажиллагааны заалт	Хэрэгжилтийн явц	Хувь
1	Байгууллагын ил тод байдал болон байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:	1.1. Аймгийн Засаг даргаар батлуулсан Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэл орон тооны бүтцийг ил тод мэдээлсэн байдалд хяналт хийх	Аймгийн засаг даргын 2022 оны А/17дугаар захирамжаар Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийн дагуу орон тооны бүтцийг батлуулсан. Эрүүл мэндийн газрын ил тод байдлын самбар болон байгууллагын вэб сайтад байршуулж ажилласан байна. Төлөвлөгөөний дагуу хяналт хийхэд ил тод байдлаар 100 байршуулсан. Орон тоо 5 дутуу ажиллаж байна.	100
		1.2. Байгууллагын 2021 оны улирлын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд дотоод хяналт хийх.	Эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд эхний хагас жилийн байдлаар хяналт хийж үзэхэд 97.3 хувьтай байна. Үүнээс мэдээлэл хожимдуулж оруулсан дараах эрүүл мэндийн байгууллагууд байна. Үүнд: Гурвансайхан, Өлзийт, Адаацаг, нэгдсэн эмнэлэг, Дэлгэрхангай сумдууд 91,4-94,0 хувьтай байна. Эдгээр байгууллагуудын дарга нар, нягтлан нарт зөвлөгөө өгч дахин хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах чиглэл өгсөн.	100
		1.3. Байгууллагын вэб сайтад шинээр мэдээлэл оруулсан эсэх, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг оруулсан байдалд хяналт хийх.	Эрүүл мэндийн газрын вэб https://du.mohs.gov.mn/ сайтад мэдээлэл бүрэн оруулсан эсэхэд 2022 оны 6 сарын 22 өдөр хяналт хийлээ. Вэб сайтад 5 мэдээлэл дутуу оруулсан. Сайтыг бүрэн гүйцэд ашиглалтад оруулаагүй байв. Хариуцсан мэргэжилтэнд зөвлөгөө өгснөөр вэб сайь бүрэн гүйцэд ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад хяналт хугацаандаа ЭМГ-ын вэб сайтад мэдээлэл оруулах үүрэг өгсөн боловч вэб сайтын холбоос хийгдээгүй байна. Энэ ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ЭМГ-ын хариуцсан мэргэжилтэд үүрэг өгч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр орууллаа.	100

		1.4 Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт хийж ил тод байдлыг нэмэгдүүлэх.	Эрүүл мэндийн байгууллагуудад ил тод байдлыг хангах чиглэлээр хяналт хийлээ. Эрүүл мэндийн байгууллагууд ил тод байдал 70 хувьтай хангагдсан байсан бөгөөд зөвлөмж өгсний дагуу ил тод байдлын самбарыг иргэдэд харагдахуйц ойлгомжтой байдлаар хийсэн байна. 11 сард хяналт дахин хийгдэнэ.	70
		1.5 Байгууллагын удирдлагын Аймгийн Засаг даргатай байгуулсан хуулиар хүлээсэн үүргийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийх.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 90,2 хувьтай хэрэгжсэн. Хугацаа болоогүй 4, эрчимжүүлэх 2, 60-70 хувьтай 2 заалтууд байв. Эрчимжүүлэх 2 заалтыг НЭМХ-ийн даргат чиглэл үүрэг өгснөөр 2022 оны 10 сарын байдлаар 15 хувиар нэмэгдсэн байна.	100
2	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж:	2.1 Байгууллагын албан хаагчдын ERP төрийн байгууллагын нэгдсэн системийн ашиглалтад хийх, үр дүнг тооцох.	2021 оны 3 сараас эхлэн ERP төрийн байгууллагын нэгдсэн системийн ашиглаж байна. Аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтнээр 1 удаа сургалт зохион байгуулсан. Дотоод хяналтын 1 удаа хийхэд 85,3 хувь ашиглаж байна. Цаашид эрчимжүүлж ажиллах чиглэлээр зөвлөгөө өглөө.	100
		2.2. ТЗ-ын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан болон ажилчдын хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт ажил дүгнэсэн байдалд хяналт хийх	Ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавихад 75-93,0 хувийн хэрэгжилттэй байв. Хэлтсийн дарга нар нь 2 дугаар улирлын ажлыг дүгнэсэн байдалд хяналт хийхэд хангалтгүй /автомат/ дүгнэх асуудал гарсан тул дахин хяналт хийж дүнг ЭМГ-ын даргат танилцуулж мэргэжилтэн тус бүрт үнэлгээний хуудсад зөвлөмж өглөө. Нийт төрийн захиргааны 14 мэргэжилтэн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу байгуулсан 5, төлөвлөгөөнд зарим ажлаа тусгаагүй 2 байв. Хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөө нэгжийн төлөвлөгөөгөөр батлагдах байсныг төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөөг давхар байгуулсан байв. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу заавар зөвлөмж өгч 4 мэргэжилтэнг буцааж батлууллаа.	100
		2.3. Мэдээ, мэдээллийн үнэн бодит байдал, мэдээ ашиглалтын байдалд хяналт хийх	Эрүүл мэндийн газраас эргэн мэдээлэл гарын авлагыг бэлтгэн гаргаж хэвшсэн. Мөн эрүүл мэндийн байгууллагуудаас авч буй мэдээ мэдээллийн үнэн зөв авч буй байдалд хяналт хийхэд зөрчил дутагдал илэрээгүй болно	100

		2.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх.	Эрүүл мэндийн салбараас гаргаж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн 88,0 хувьтай байна. Эрчимжүүлэх 1 заалт байна. Энэ нь 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 засгийн газрын хуралдааны тэмдэглэл байв. Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн чиг үүрэгт хамаарах тул албан бичгээр эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд эрчимжүүлэх чиглэл өгсөн. Үүний үр дүн 16,4 хувь болж өссөн байна.	70
		2.7. Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж зөвлөн туслаж ажиллах.	Эхний хагас жилийн эмнэлгийн удирдлага зохион байгуулалт, санхүү, хүний нөөц, мэдээ мэдээлэл, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт үнэлгээг 11 суманд зохион байгуулаад байна. Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч зөвлөмжийг хүргүүллээ. 2022 оны 11 сард дахин хяналт хийж зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийнэ.	61,1
3	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, ажилчдын ёс зүй, хариуцлага	3.1. Ажлын цаг ашиглалт, үр дүнд дотоод хяналтыг хийх.	Нийт 21 эрүүл мэндийн байгууллага хурууны хээгээр уншиж ажлыг цагийг бүртгэлийг хийж хэвшсэн. Одоогийн байдлаар хурууны хээгээр цаг бүртгэх ажлыг ковид 19-ын нөхцөл байдалтай холбоотойгоор түр хойшлогдсон бөгөөд 2022 оны 7 сараас эхлэн ERP программыг ашиглан ажлын цагийг бүртгэж эхэлсэн Үүнтэй холбоотойгоор ажлын цагийн ашиглалт бүртгэл сайжирсан байна.	100

Хэрэгжилтийн дундаж 91,0

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН П.ОЮУНЧИМЭГ